210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,460,400.00	1,377,800.00	82,600.00	94.34
210803	Даатгалын үйлчилгээ	118,300.00	118,300.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84,500.00	84,500.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	59,800.00	59,800.00	-	100.00
210807	Газрын төлбөр	29,900.00	29,900.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,111,800.00	2,111,800.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,730,900.00	12,730,900.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,730,900.00	12,730,900.00	-	100.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	682,242,700.00	690,285,300.00	(8,042,600.00)	101.18
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,770,000.00	43,770,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	43,770,000.00	43,770,000.00	-	100.00
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	635,413,700.00	563,652,400.00	71,761,300.00	88.71
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	635,413,700.00	563,652,400.00	71,761,300.00	88.71
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	79,803,900.00	(79,803,900.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	79,803,900.00	(79,803,900.00)	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,059,000.00	3,059,000.00	-	100.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,400,000.00	1,400,000.00	-	100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,659,000.00	1,659,000.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,902,229.74	(9,902,229.74)	
	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй болно.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төв нь эмнэлгийн ёс зүйг эрхэмлэн дээдэлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг ур чадварын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэж, эрүүл аж төрөх зөв дадлыг эзэмшүүлэх зорилго тавьсан байна.

Алаг-Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эмнэлгийн болон эрүүл мэндийн тусламжийн чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Хүний нөөцийн чадавхыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг тасралтгүй хөгжүүлэх
- Өрх, иргэн төрийн ба төрийн бус байгууллагын ажилтан албан хаагч бүрд эрүүл мэндийн боловсрол олгож, зөв дадал хэвшилд сургах, хамтран ажиллах
- Иргэдэд ээлтэй орчин бүрдүүлж, сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэх
- Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүйг эрхэмлэн ажиллах

### 3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

#### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам<sup>1</sup>-ийн дагуу Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 сарын 10-ны өдрийн А/46 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 9 заалт бүхий 43 ажлын төлөвлөгөө гаргаж хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

<sup>1</sup> “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

<sup>2</sup> “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

**Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан** дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, Эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,422.6 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		9,902.2	-9,902.2
Авлага	79,803.9	49.7	-79,754.2
Бараа материал	86,004.4	90,657.9	4,653.5
Үндсэн хөрөнгө	332,707.3	352,483.1	19,775.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>498,515.5</b>	<b>453,092.9</b>	<b>-45,422.6</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	333,916.1	333,916.1	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>498,515.5</b>	<b>453,092.9</b>	<b>-45,422.6</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал данс өссөн үзүүлэлттэй байна.

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 9,902.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 4,653.5 мянган төгрөгөөр өссөн хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, бусад хангамжийн материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 19,775.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 56,704.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 21,099.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч 35,605.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Нэмэлт санхүүжилт байхгүй байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт 649,303.9 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 39,300.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 635,413.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 43,770.00 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан байна. 83603 хөтөлбөр дээр 3059,0 төгрөгийн төсөв батлагдсанаас төлөвлөгөөний нийт дүн 682,242.7 мянган төгрөг болсон.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 635.413.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 1,859.6 мянган төгрөгийн үлдэгдэл эрх нээгдээгүй гүйцэтгэлийн санхүүжилт 8,042.6 мянган төгрөг нийт 9,902.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 43,770.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 00.0 мянган төгрөг байна.

Орон нутгийн төсөв нь нийтлэг үйлчилгээний зардал 13,050,0 төгрөгөөр нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой зардал 8,580.0 мянган төгрөгөөр буурч батлагдсан.

ЭМД-ын сангийн төсөв 167,303.9 мянган төгрөгөөр буурч 482,000.0 төгрөгөөр анх батлагдсан ба тайлант хугацааны явцад гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн төсөв, зарцуулах эрхийн хамт нэмэгдсэнээр нийт төсөв 635,413.7 мянган төгрөг болсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 680,383.1 мянган төгрөг буюу 99.73 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	309,310.7	308,964.8	345.9	99.9%
2	Үндсэн тусламж үйлчилгээ	233,149.1	231,635.4	1,513.7	99.3%
3	Дээд шатны төсвөөс хувиарласан	96,012.9	96,012.9	0	100%

4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	30,720.0	30,720.0	0	100%
5	Нийтлэг үйлчилгээ	13,050.0	13,050.0	0	100.0%
	Дүн	682,242.7	680,383.1	1,859.6	99.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 79,803.9 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, үлдэгдлийг Улсын төсвийн харилцах данс руу хааж бичилт хийж тайлагнасан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 865,979.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 17,319.6 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 108,826.9 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн тул аудитаар зөвлөмж хүргүүлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй ба төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 3,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг ханган биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Зөвлөмж	1	3,500.0	1	3,500.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3,500.0</b>	<b>1</b>	<b>3,500.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 45,223.3 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 210,867.6 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 84,832.6 мянган төгрөгийн алдааг залруулж, төлбөрийн акт 1,352.6 мянган төгрөг, 124,682.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 79,803.9 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны ЭМД-аас авсан санхүүжилт дээр нэмж Мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 5,028.7 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэсэнийг тус тус залруулав.

Аудитаар нийт 126,035.0 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс, 1,352.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 124,682.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлын нэмэгдэл хөлсийг шалгахад 4 хүнд 1,352.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү бодож олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 2 дугаар хавсралтын Нэмэгдэл хөлс олгох 3 дугаар зүйлийн 3.3 Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 "Ажлын дараалсан хоёр өдрийн хоорондох тасралтгүй амралт 12 цаг ба түүнээс дээш хугацаатай байна" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд 49.7 мянган төгрөгийн авлага үүсгэж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийг зөв зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, авлага үүсгэхгүй ажиллах

#### 2. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 1,581.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,

**3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 14,224.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

**4. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 108,826.9 мянган төгрөгийн 5 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	79,803.9			1	79,803.9	1	79,803.9				
Эдийн загийн ангилал буруу сонгосон	1	5,028.7			1	5,028.7	1	5,028.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>84,832.6</b>			<b>2</b>	<b>84,832.6</b>	<b>2</b>	<b>84,832.6</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэхгүй байх	1	49.7					1	49.7				
Ажилтнуудад илүү цагийн хөлсийг илүү тооцсон	1	1,352.6	1	1,352.6								
Үр дүнгүй зардал гаргасан	1	1,581.0					1	1,581.0				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	14,224.8					1	14,224.8				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>17,208.1</b>	<b>1</b>	<b>1,352.6</b>			<b>3</b>	<b>15,855.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	108,826.9						1	108,826.9
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>108,826.9</b>						<b>1</b>	<b>108,826.9</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Х.ДИЙМАА

АУДИТОРЫН МЕНЕЖЕР

Л.МАГСАРЖАЛАМ

